



Амазоны Хяналт (Amazon Watch)– Азийн уугуул иргэдийн пакт (AIPP)– Байгаль орчныг батлан хамгаалах Америк тивийн холбоо (Asociación Interamericana para la Defensa del Ambiente / AIDA) –Бианка Жазгер Хүний Эрхийн Сан (Bianca Jagger Human Rights Foundation) – Нүүрстөрөгчийн зах зээлийн хяналт (Carbon Market Watch) – Даниел Миттераны сан (Fondation Danielle Mitterrand-France Libertés) – Олон улсын голууд (International Rivers) – Байгаль орчны төлөөх Залуу сайн дурынхан (Youth Volunteers for the Environment-JVE)– Амьд голууд хөдөлгөөн (Movimiento Ríos Vivos-MRV) – Оксфам Интернэйшнл (Oxfam International)–Далангийн эсрэг, гол мөрөн, нутгийн иргэд ба усны төлөөх Латин Америкийн сүлжээ (Latin American Network against Dams and for Rivers, Communities and Water-REDLAR) – Хил хязгааргүй гол мөрөн (Rivers Without Boundaries) – Urgewald

Уур амьсгалын санаачлагуудад томоохон усан цахилгаан станцуудыг оруулж болохгүй арван шалтгаан

Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх бодит шийдлүүдийг дэмжсэн иргэний нийгмийн байгууллагуудын тунхаг

Олон улсын санхүүжүүлэгч байгууллагууд, улс орнуудын засгийн газар болон бусад оролцогчид ихэнх тохиолдолд усан цахилгаан станцын том төслүүдийг эрчим хүчний “цэвэр болон ногоон” эх үүсвэр хэмээн сурталчилдаг. Эдгээр төслүүд нь Цэвэр Хөгжлийн Механизм (ЦХМ)-ын нүүрстөрөгчийн кредит, Дэлхийн Банкны Уур амьсгалын хөрөнгө оруулалтын сангаас олгодог зээл, мөн экспортын зээлийн агентлагуудаас үзүүлдэг санхүүгийн тусгай нөхцөл, ногоон бонд зэрэг уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх механизмуудаас нэлээдгүй дэмжлэг авдаг. Далан барьдаг компаниуд нь усан цахилгаан станцын томоохон төслүүдийг Ногоон уур амьсгалын сангаас санхүүжүүлэхийг дэмждэг бөгөөд цөөнгүй орны засгийн газрууд өөрийн орны санаачлагуудын хүрээнд эдгээр төслийг уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх арга хэмжээ хэмээн ихээхэн дэмжиж байна. Жишээлбэл, томоохон усан цахилгаан станцын салбартай дор хаяж арван хоёр орны засгийн газрууд Улсын хэмжээнд тодорхойлж санал болгож буй хувь нэмрийн тухай (Intended Nationally Determined Contributions / INDCs) тайландаа усан цахилгаан станцаас гаргах эрчим хүчээ нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна.

Уур амьсгалын санаачлагуудаас санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа нь 3,700 хол давсан усан цахилгаан станцын далангууд одоогоор баригдаж, төлөвлөгдөж байгаагийн нэг шалтгаан юм. Гэсэн хэдийч **усан цахилгаан станцын том төслүүд нь дэлхийн уур амьсгалын**

асуудлыг шийдвэрлэх хуурамч шийдэл юм. Эдгээр төслүүдийг дараах үндэслэлээр үндэсний болон олон улсын уур амьсгалын санаачлагуудад хамруулж болохгүй, үүнд:

1. Ялангуяа халуун уур амьсгалтай бүс нутагт усан цахилгаан станцын усан сангаас **их хэмжээний хүлэмжийн хий ялгарч** байдаг. Судлаачдын хянасан судалгааны үр дүнгээс харахад [хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй уур амьсгалын өөрчлөлтөд 4-өөс дээш хувь](#) буюу нисэхийн салбараас дэлхийн уур амьсгалд үзүүлэх нөлөөлөлтэй дүйцэхүйц хэмжээний нөлөөлөл үзүүлэх метаны хий эдгээр усан сангаас ялгарч байна. Зарим тохиолдолд усан цахилгаан станцын төслүүд ижил хэмжээний эрчим хүч үйлдвэрлэдэг [нүүрсээр ажилладаг цахилгаан станцуудаас давсан хэмжээний хүлэмжийн хий](#) ялгаруулж байна.
2. Голууд жилд ойролцоогоор 200 сая тонн нүүрстөрөгчийн хийг агаар мандлаас шингээж байдаг. Үүнээс гадна Амазон, Конго, Ганга болон Меконг голуудын далай руу зөөж оруулдаг лаг шавар нь планктоныг хооллон их хэмжээний нүүрстөрөгчийн хийг шингээж байдаг. Усан цахилгаан станцын төслүүд болон бусад төрлийн далангууд нь лаг шавар, шим тэжээлийн бодисыг далай руу тээвэрлэхэд саад болсноор **дэлхийн нүүрстөрөгчийн хийг шингээхэд голуудын гүйцэтгэдэг үүрэгт сөргөөр нөлөөлдөг.**
3. Усан цахилгаан станцын далангуудаас болж **ус болон эрчим хүчний систем уур амьсгалын өөрчлөлтөд илүү өртөмтгий эмзэг болдог.** Урьд өмнө тохиолдож байгаагүй үер нь далангуудын аюулгүй байдалд эрсдэл учруулж байна: Зөвхөн АНУ-д гэхэд 2010 [оноос хойш 100 гаруй далан нурсан байна.](#) Далан барьснаар Энэтхэгийн Уттаракханд зэрэг эмзэг уулархаг нутаг дахь үерийн гамшигийг улам нэмэгдүүлэх болсон. Үүнтэй зэрэгцээд хэт их ган гачигийн тохиол ихсэж байгаа нь усан цахилгаан станцын эдийн засгийн эрсдлийг нэмэгдүүлж Африкын орнуудаас авахуулаад Бразил зэрэг эрчим хүчний хувьд усан цахилгаан станцаас хамааралтай орнуудад ихээхэн нөлөөлж байна.
4. Ихэнх салхи, нарны болон бичил усан цахилгаан станцын төслүүдээс ялгаатай зүйл гэвэл далангууд нь **онц чухал экосистемд ноцтой, мөн ихэнх тохиолдолд эргэж буцахааргүй хохирол** учруулж байдаг. Далан барих болон бусад зарим хүчин зүйлийн улмаас цэнгэг усны экосистемүүд 1970 оноос хойш дунджаар [76 хувиар доройтон тоо толгойгоо алдсан](#) бөгөөд энэ нь далайн болон эх газар дээрх экосистемийн доройтлоос их байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс экосистемийг хамгаалахаар улам их тооны далан барина гэдэг нь манай дэлхийн уушгийг хамгаалахын тулд түүний артерийг золиосолсонтой ижил юм.
5. Усан цахилгаан станцын том төслүүд нь **орон нутгийн иргэдэд ноцтой сөрөг нөлөөлөл үзүүлээд** зогсохгүй **нутгийн уугуул иргэдийн** газар, газар нутаг, байгалийн нөөц эзэмших, тэдгээрийн соёлын бүрэн бүтэн байдал, засаглал, чөлөөтэй, урьдчилан мэдээлэл авсны үндсэн дээр шийдвэр гаргах **эрхийг ихэнх тохиолдолд зөрчиж** байдаг. Далангуудын нөлөөллийн улмаас [дор хаяж 40-80 сая хүн газар нутгаа орхиж нүүснээс](#) гадна голын [доод хэсэгт амьдардаг 472 сая гаруй хүний](#) амьдралд сөргөөр нөлөөлсөн байна. Далангийн сөрөг нөлөөлөлд өртсөн олон нийтийн эсэргүүцэл ихэвчлэн хүний эрхийг бүдүүлгээр зөрчих явдалтай тулгарч байна.
6. Усан цахилгаан станцын том төслүүд нь **ядуу иргэдийн эрчим хүчний хүртээмжийг сайжруулах үр дүнтэй хэрэгсэл тэр бүр болж чаддаггүй.** Ихэнх салхи, нарны болон бичил усан цахилгаан станцын төслүүдээс ялгаатай зүйл гэвэл том усан цахилгаан станцуудын далангууд эрчим хүчний төв системээс хамааралтай байдаг бөгөөд энэ нь ялангуяа Саб Сахарын Африк болон [Гималайн хөдөөгийн хүн амд хүрэх хямд өртөгтэй шийдэл байдаггүй.](#) Том усан цахилгаан станцуудын төслүүдийг ядуу иргэдийн эрчим

хүчний хэрэгцээг хангах зорилготой хэмээн зөвтгөдөг боловч уул уурхайн болон аж үйлдвэрийн төслүүдийн хэрэгцээг хангах зорилгоор хэрэгжүүлэх нь олонтаа байдаг.

7. Өөр бусад сайн шийдэл байсан ч гэсэн том усан цахилгаан станцын төслүүд нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд **зардал ихтэй, их цаг хугацаа шаардсан шийдэл** байх болно. Том далангуудын [бодит өртөг төлөвлөсөн хэмжээнээсээ дунджаар 96 хувиар хэтэрдэг бол цаг хугацаны хувьд 44 хувиар анх төлөвлөсөн хугацаанаасаа хоцорч байдаг](#). Харьцуулбал салхи, нарны эрчим хүчний төслүүдийг харьцангуй богино хугацаанд хэрэгжүүлж болдог бөгөөд эдгээр төслүүдийн өртөг дунджаар 10 хүрэхгүй хувийн хэтрэлттэй байдаг.
8. Салхи, нарны эрчим хүчний төслүүдтэй харьцуулбал **усан цахилгаан станц нь технологийн инноваци гэж тооцогдохоо нэгэнт больсон** ба сүүлийн хэдэн арван жилд том хэмжээний техникийн ололт гаргаагүй байна. Нарны эрчим хүчнээс ялгаатай зүйл гэвэл том усан цахилгаан станцын төслүүдэд уур амьсгалын санаачлагуудаас олгох санхүүжилт нь үйлдвэрлэлийн зардлыг бууруулж чадахгүйн зэрэгцээ Өмнөдийн улс орнуудад шинэ технологи дамжуулах хөшүүрэг болж чадахгүй.
9. Салхи, нарны эрчим хүчийг [нэгэнт үйлдвэрлэх боломжтой болсны зэрэгцээ санхүүгийн хувьд өрсөлдөх чадвартай](#) болсноос гадна эрчим хүчний шинэ эх үүсвэрийн хувьд том усан цахилгаан станцуудаас илүү хувь эзлэх болсон. Эрчим хүчний сүлжээ ухаалаг болохоос гадна эрчим хүч хадгалах зайны өртөг буурч байгаа тул усан цахилгаан станцын шинэ төслүүд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн тасалдлыг нөхөх шаардлагагүй болсон.
10. Одоогоор усан цахилгаан станцын төслүүд [Цэвэр Хөгжлийн Механизмд бүртгэлтэй нийт төслүүдийн 26 хувийг](#) эзэлж байгаагаас гадна уур амьсгалын бусад санаачлагуудаас ихээхэн хэмжээний санхүүгийн дэмжлэг авч байна. Том усан цахилгаан станцуудад уур амьсгалын санаачлагуудаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь нар, салхины эрчим хүч, бичил усан цахилгаан станц зэрэг уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх **жинхэнэ шийдлүүдэд олгох санхүүгийн дэмжлэгээс хумслахад** хүргэж байгаагийн зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх бодит арга хэмжээ гэсэн хуурмаг дүр зураг бүрдүүлж байна. Том усан цахилгаан станцын төслүүдийг уур амьсгалын санаачлагуудад хамруулах нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх нэмэлт бодит шийдэл эрэлхийлэх хэрэгцээг хуурамчаар мартаход хүргэж байна.

Дээрх шалтгаануудын улмаас энэхүү тунхагт гарын үсэг зурсан байгууллагууд, хувь хүмүүс **засгийн газрууд, санхүүжүүлэгч байгууллагууд, мөн бусад байгууллагуудад хандаж уур амьсгалын санаачлагуудад том усан цахилгаан станцуудын төслүүдийг хамруулахгүй байхыг уриалж байна. Уур амьсгалын болон эрчим хүчний бүх шийдлүүд орон нутгийн иргэдийн эрх, тэдгээрийн амьжиргааг хүндлэх ёстой.**

SPONSORS:

Asia Indigenous Peoples Pact • Asociación Interamericana para la Defensa del Ambiente • Amazon Watch • Bianca Jagger Human Rights Foundation • Carbon Market Watch • France Liberte • International Rivers • Jeunes Volontaires pour

l'Environnement International • Oxfam International • REDLAR • Rios Vivos • Rivers Without Boundaries • South Asia Network on Dams, Rivers and People • Urgewald

CO-SIGNERS:

Afghanistan

Youth for Change Afghanistan Organization (YCAO)

Argentina

Asociación Ambientalista MayuSumaj - Asociación Amigos de los Parques Nacionales
- La Asociación Amigos de los Parques Nacionales (AAPN)

Armenia

EcoClub "Tapan"

Australia

Aboriginal Rights Coalition

Bangladesh

Alliance for Cooperation and Legal Aid Bangladesh (ACLAB) - Awaj Foundation -
Badhan Hijra Sangha (BHS) - Bangladesh Adivasi Forum (BAF) - Bangladesh Centre
for Human Rights and Development (BCHRD) - Center for Bangladesh Studies (CBS)
- Chittagong Hill Tracts Citizens' Committee (CHTCC) - Chittagong Hill Tracts
Indigenous Jumma Association - CLEAN (Coastal Livelihood and Environmental
Action Network) - Dhaka Single Women Association (DSWA) - EquityBD - JAGO
NARI - Kapaeeng Foundation (KF) - Light House - Participatory Research Action
Network (PRAN) - Peoples Development Community (PDC) - UBINIG (Policy
Research for Development Alternative) - Zabarang Kalyan Samity (ZKS)

Brazil

Articulação de Mulheres Brasileiras - Articulação dos Povos Indígenas do Brasil -
APIB - Apremavi - Associação de Preservação do Meio Ambiente e da Vida -
Associação Ambientalista Corrente Verde - St^a M^a da Vitória-Bahia - Associação de
Defesa Etnoambiental - Kanindé - CNLB - Coletivo de Mulheres de Altamira -
Comissão Paroquial de Meio Ambiente (CPMA) - Caetite - Ecoa - Ecologia e Ação -
Folha de Ipiíba - Forum da Amazônia Oriental - FAOR - Forum em Defesa de
Altamira - Fórum Mudanças Climáticas e Justiça Social - Fundação Tocaia - Grupo
Semente - Instituto Brasileiro de Análises Sociais e Econômicas (IBASE) - Instituto
GAIA - Instituto Panamericano do Ambiente e Sustentabilidade (IPAN) - Movimento
dos Atingidos por Barragens (MAB) - Movimento Munduruku Ipereg Ayu - Movimento
Tapajós Vivo - Movimento Xingu Vivo Para Sempre (MXVPS) - O Grupo de Defesa da
Amazônia - Operação Amazônia Nativa - OPAN - UFPA

Burkina Faso

Centre de Documentation et de Recherche Economiques et Sociales (CEDRES)

Cambodia

Banteay Srei - Cambodia Indigenous Youth Association (CIYA) - Equitable Cambodia
- Highlanders' Association (HA) - Positive Change for Cambodia (PCC)

Cameroon

Green Development Advocates

Canada

Atlantic Regional Solidarity Network

Chile

Agrupación Cultural Wekeche - Agrupación Ecológica Altué - Amigos del Río San Rodrigo - Chile Sustentable - COMISIÓN JUSTICIA Y PAZ - Comité Pro Defensa de la Fauna y Flora (CODEFF) - Consejo de Defensa de la Patagonia Chilena (CDP) - Corporación Chile Ambiente - Corporación Privada para el Desarrollo de Aysén - Ecosistemas - Etica en los Bosques - Fiscalía de Medio Ambiente (FIMA) - Fundación Nahuelbuta - Fundación Terram - Futaleufú Riverkeeper - Geute Conservación Sur - Observatorio Ciudadano - ONG FIMA - Verdeseo - Agrupacion Aysen Reserva de Vida - Colalición Ciudadana Aysén Reserva de Vida - Coalición Ecuménica por el Cuidado de la Creación

China

Taiwan Associaton for Rights Advancement for Ping Pu Plains. Aborigine Peoples (TARA-Ping Pu)

Colombia

Asociación Ambiente y Sociedad - ASPROCIG - Censat Agua Viva - Instituto Latinoamericano para una Sociedad y un Derechos Alternativos (ILSA) - Movimiento Rios Vivos

Costa Rica

Asada Santa Cecila - COECOCEIBA - La Asociación Amigos de los Parques Nacionales (AAPN) - Fundación Neotrópica - Movimiento en defensa de los rios de Dota - PROAL-JAKUII (Proyectos alternativos/Pacuare) - UCR

Democratic Republic of Congo

Actions pour les Droits, l'Environnement et la Vie (ADEV) - La Coalition Réforme et Action Publique (CORAP) - Le Conseil Regional des Organisations Non Gouvernementales de Developpement (CRONGD)

Denmark

International Work Group for Indigenous Affairs (IWGIA)

Dominican Republic

Brigada Cimarrona Sebastián Lemba

Ethiopia

Ethiopian Human Rights Council

France

Fondation Danielle Mitterrand-France Libertés - International Council for the Indigenous Peoples of CHT (ICIP-CHT)

Georgia

Center of Innovative Development of Enterprises, EaP National Platform WG - Green Alternative

Germany

Urgewald

Guatemala

Breaking the Silence Maritimes-Guatemala Solidarity Network - CERIxim, el Colectivo de Estudios Rurales Ixim - Colectivo MadreSelva

India

Adivasi Women's Network (AWN) - Association for Promotion Sustainable Development (APSD) - Bharat Jan Vigyan Jatha - Bible Hill Youth Club - Borok Peoples' Human Rights Organisation (BPHRO) - Center for Advancement of Public Understanding of Science & Technology (CAPUST) - Centre for Research and Advocacy, Manipur (CRAM) - Civil Society Women Organization (CSWO) - Clean Energy Access - Empower INDIA - Forum for Policy Dialogue on Water Conflicts in India - Society for Promoting Participative Ecosystem Management (SOPPECOM) - Gram Bharati Samiti (GBS) - Gramya Resource Centre for Women - India Climate Justice Platform - India Network on Ethics and Climate Change - Indigenous Perspectives - INECC - Lok Shakti Abhiyan - Manthan Adhyayan Kendra - Mishing Bane Kebang - Naga Peoples Movement for Human Rights (NPMHR) - Paryavaran Suraksha Samiti - River Research Centre - Samajik Seva Sadan - Sikkim Bhutia Lepcha Apex Committee - Society for Promoting Participative Ecosystem Management (SOPPECOM) - South Asian Dialogues on Ecological Democracy - South Asia Network on Dams, Rivers & People - The Timbaktu Collective - The Vigyan Vijay Foundation, New Delhi - ToxicsWatch Alliance (TWA) - VIKALP - Zo Indigenous Forum (ZIF) - Zomi Human Rights Foundation (ZHRF)

Indonesia

Aliansi Masyarakat Adat Nusantara (AMAN) - Inspirator Muda Nusantara - Serikat Perempuan Indonesia (Indonesian Women Organization) (SERUNI) - WALHI Jawa Barat

Italy

SONIA for a Just New World (SONIA)

Kazakhstan

Feminist League - "Jabagly-Manas" Mountain Club Public Association

Kenya

Indigenous Information Network (IIN) - International Alliance of Indigenous and Tribal Peoples of the Tropical Forests (IAITPTF) - Jamaa Resource Initiatives - Sengwer Indigenous Peoples Programme

Kyrgyzstan

Central Asia Toxic Action Network

Malaysia

#PowerShiftMsia - Borneo Project - Borneo Resources Institute (BRIMAS) - Communities' Information and Communications Centre (CICOM) - Community-Led Environmental Awareness for our River (CLEAR) - Jaringan Orang Asal SeMalaysia (JOAS) - Partners of Community Organisations (PACOS Trust) - Persatuan Belia Perubahan Iklim - Sarawak Citizens Movement (GASAK) - Sarawak Natives Customary Land Rights Network - SAVE Rivers Network

Mauritania

ONG Mer Bleue

Mexico

Agencia Internacional de Prensa Indígena (AIPIN) - CeIBA AC - Centro de Análisis e Investigación - Congreso Nacional de Comunicación Indígena (CNCI) - FUNDAR - Otros Mundos AC - Prodefensa del Nazas, A.C. - Servicios para una Educación Alternativa

Moldova

Eco-TIRAS International Association of River Keepers

Mongolia

Centre for Human Rights and Development (CHRD) - Gobi Soil - OT Watch - Rivers without Boundaries International Coalition - Steps Without Borders

Myanmar

Chin Human Rights Organization (CHRO) - Justice and Peace Commission (JPC)/Catholic Bishops' Conference of Myanmar (CBCM) - Nationalities Youth Forum (NYF) - Promotion Of Indigenous and Nature Together (POINT)

Nepal

Active Society Nepal (ASN) - Ageing Nepal - Beyond Beijing Committee (BBC) - Beyond Beijing Committee (BBC) - Center for Indigenous Peoples' Research and Development (CIPRED) - Federation of Nepalese Indigenous Nationalities Journalists (FONIJ) - Indigenous Nationalities Women Youth Network (INWYN) - Kirat Chamling Association (KCA) - Kirat Chamling Language Culture Development Association (KCLCDA) - Kirat Chamling Youth Society (KCYS) - Kirat Welfare Society (KWS) - Kirat Youth Society (KYS) - Kulung Mimchha Guskham (KMG) - Lawyers' Association for Human Rights of Nepalese Indigenous Peoples (LAHURNIP) - National Forum for Advocacy, Nepal (NAFAN) - Nepal Federation of Indigenous Nationalities (NEFIN) - Nepal Kirat Kulung Bhasa Sankskriti Utthan Sangh (NKKBSUS) - Nepal Magar Association (NMA) - People Unity Youth Society (PUYS) - SunFarmer - United Coalition of Against All Discrimination, Nepal (UCAAD) - Unity Society - Youth Awareness Society Nepal (YASN) - Youth Federation of Indigenous Nationalities, Nepal (YFIN)

Netherlands

Both ENDS - Netherlands Centre for Indigenous Peoples (NCIV) - River Basin Friends (NE)

Nicaragua

Centro de los Derechos del Campesino (CEDECAM) - Centro para la Autonomía y Desarrollo de los Pueblos Indígenas (CADPI)

Nigeria

Labour, Health and Human Rights Development Centre

Pakistan

Advocacy, Research, Training and Services (ARTS) Foundation - DAMAAN Development Organization

Panama

Alianza para la Conservacion y el Desarrollo (ACD) - Centro de Incidencia Ambiental (CIAM)

Peru

Centro de Promocion Estudios de la Mujer - Instituto Jajachupan - Movimiento

Ciudadano frente al Cambio Climático (MOCICC) - Paz y Esperanza

Philippines

Alyansa Tigil Mina (Alliance Against Mining) - Asia Indigenous Peoples Network on Extractive Energy and Industries (AIPNEE) - Asia Pacific Indigenous Youth Network (APIYN) - Asia Pacific Research Network (APRN) - Asian Peoples' Movement on Debt and Development (APMDD) - BAI Indigenous Women's Network - Center for Women's Resources (CWR) - Cordillera Disaster Response & Development Services (CorDis RDS), Inc. - Cordillera Indigenous Peoples Legal Center (DINTEG) - Cordillera Peoples Alliance (CPA) - International Indigenous Peoples Movement for Self Determination and Liberation (IPMSDL) - KALIKASAN-People's Network for the Environment - Kalipunan ng Mga Katutubong Mamamayan ng Pilipinas (KATRIBU) - Migrante International - NGO Forum on ADB - Philippine Rural Reconstruction Movement (PRRM) - Philippine Task Force for Indigenous Peoples Rights (TFIP) - Tebtebba (Indigenous Peoples' International Centre for Policy Research and Education) - Tribal Government of the Philippines

Russia

Altai Regional Public Fund for 21st Century Altai - Amur Ecological Club Ulukitkan - Arkhangelsk Regional Youth Ecological Public Organisation (Aetas) - Association of Environmental Journalists - Biodiversity Conservation Center - Bureau for Regional Outreach Campaigns (BROC) - Buryat Regional Association on Lake Baikal - Center for Support of Indigenous Peoples of the North (CSIPN) - Council of the All-Russian Public Organization "Socio-Ecological Union" (SEU) - ECA Green Movement - Ecological Center "Dront" - Environmental Watch on North Caucasus - Great Baikal Trail Association-Buryatia - Green Branch - Green Cross - Green Don - Institute of General and Experimental Biology SB RAS - Interregional Environmental Organization ECA - Interregional Non-Governmental Environmental Foundation ISAR-Siberia - IPEN/Eco-Accord - ISAR-Siberia - Kola Biodiversity Conservation Center - Krasnoyarsk Regional Environmental Public Organization "Plotina" - Magadan Centre of Environment - NGO Environmental Watch on the North Caucasus - Public Ecological Centre of the Republic of Sakha (Yakutia) - Public Environmental Monitoring Network of The Sakha Republic - Rivers without Boundaries International Coalition - Russian Ecological Congress - Socio-Ecological Union (SEU) International - The Third Planet from the Sun

Senegal

ARCADE - Lumière Synergie pour le Développement

Sri Lanka

Earth Environment Protect Organization (EEPO) - Sevalanka Foundation

Switzerland

Bruno Manser Fund

Tajikistan

Foundation to Support Civil Initiatives (FSCI)

Tanzania

Pastoralists Indigenous Non-Governmental Organization's Forum (PINGO's Forum)

Thailand

Asia Pacific Forum on Women, Law and Development (APWLD) - Community Resource Centre - Focus on the Global South Mangrove Action Project - Sustainable Development Foundation (SDF)

Uganda

National Association of Professional Environmentalists (NAPE) - Uganda Land Alliance (ULA)

United Kingdom

Bianca Jagger Human Rights Foundation - Forest Peoples Programme (FPP) - International Tibet Network

United States

Amazon Watch - Bank Information Center - Center for International Environmental Law (CIEL) - EarthRights International (ERI) - Friends of the Earth US - Gender Action - Inclusive Development International (IDI) - Institute for Policy Studies - International Accountability Project - Natural Resources Defense Council (NRDC) - Rainforest Action Network - St. George Island Institute

Uruguay

CEUTA

Uzbekistan

Public Association "EKOLANDSKAPE"

Vietnam

CCD - Centre for Sustainable Community Development (S-CODE) - Centre for Sustainable Development in Mountainous Areas (CSDM) - Centre of Research and Development in Upland Areas (CERDA) - Experimental School - FREC - Ho Chi Minh National Politic Academy - People and Nature Reconciliation - Vietnam Indigenous Knowledge Network (VTIK)

International

Asia Indigenous Peoples Pact (AIPP) - Asociación Interamericana para la Defensa del

Ambiente (AIDA) - CEE Bankwatch Network - Carbon Market Watch - International Rivers - International Socio-Ecological Union - Jeunes Volontaires pour l'Environnement (JVE) - Oxfam - REDLAR

Эх сурвалж: <http://www.internationalrivers.org/node/9204>